

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2021/2/СТА-ТЭЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2021 он</p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор: Я.Самбууням Утас: 260949 Цахим хаяг: Sambuunyamy@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Нарангэрэл Утас: 260512 Цахим хаяг: Narangerelba@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал.	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө	12
3.5.2 Авлага	13
3.5.3 Урьдчилгаа	14
3.5.4 Бараа материал.....	15
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө.....	15
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	16
3.5.8 Өр төлбөр	16
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	19
3.8 Аудитын гол асуудал.....	20
3.9 Шилэн дансны мэдээлэл.....	20
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал	21
4. Аудитын илрүүлэлт	21
Залруулсан алдаа.....	21
Зөвлөмж	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	23
6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХК	Хувьцаат компани
ХНН	Хувь нийлүүлсэн нийгэмлэг
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

2021. 04. 26 № 1318
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

A red rectangular official stamp is positioned over a handwritten signature in black ink. The signature is written in a cursive style and appears to read 'Д.ЗАНДАНБАТ'. The stamp contains Mongolian text, including the name 'Д.ЗАНДАНБАТ' and the title 'Д.ЗАНДАНБАТ'.

Д.ЗАНДАНБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөө/

Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	667,551,229.2	135,783,838.6
Мөнгөн хөрөнгө	68,779,108.6	25,490,665.1
Авлага	17,809,490.6	7,946,570.3
Урьдчилгаа	12,375,578.4	10,529,232.3
Бараа материал	21,369,070.8	14,215,466.0
Бусад эргэлтийн хөрөнгө	547,217,980.7	77,601,904.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	472,308,080.7	223,727,753.5
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	500.0	0.0
Үнэт цаас	500.0	0.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	472,307,580.7	223,727,753.5
Биет хөрөнгө	330,476,636.6	205,505,871.6
Биет бус хөрөнгө	136,465,057.7	18,221,881.9
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	5,365,886.4	0.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,139,859,309.9	359,511,592.0
НИЙТ ӨР ТӨЛБӨР	125,310,075.5	5,804,637.3
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	31,326,473.7	5,369,968.1
Богино хугацаат зээлийн өглөг	1,406,848.8	0.0
Өглөг	25,642,457.7	2,417,297.4
Урьдчилж орсон орлого	4,277,167.2	2,952,670.7
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	93,983,601.8	434,669.2
Урт хугацаат зээл	93,983,601.8	434,669.2
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,014,549,234.4	353,706,954.7
Засгийн газрын хувь оролцоо	1,011,026,199.2	353,706,954.7
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрынсан/ орон нутгийн сан	139,989,278.1	34,911,102.9
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	147,631,409.2	31,701,644.9
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	2,538,512.2	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	55,197,475.2	1,445,095.0
Хуримтлагдсан үр дүн	619,905,415.0	245,759,078.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	45,764,109.6	39,890,032.9
Хяналтын бус хувь оролцоо	3,523,035.2	0.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,139,859,309.9	359,511,592.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	514,279,940.3	349,797,391.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	216,425,983.4	206,126,408.3
120	Нийтлэг татварын бус орлого	215,968,223.9	204,872,522.7
121	Хөрөнгийн орлого	434,353.8	445,622.2
122	Тусламжийн орлого	23,405.7	808,263.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	297,853,956.9	143,670,983.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	305,791,192.1	324,636,674.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	305,791,192.1	324,636,674.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	140,718,729.6	144,064,713.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	50,726,937.8	54,149,227.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,468,718.2	2,209,525.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,803,722.8	387,136.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,216,022.3	405,921.1
2105	Нормативт зардал	69,530.8	59,197.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,391,795.0	122,623.2
2107	Томилолт, зочны зардал	619,618.3	121,261.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,109,546.4	11,602,382.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,312,837.8	75,007,438.6
212	ТАТААС	695,375.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	164,377,087.5	180,571,960.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	208,488,748.2	25,160,717.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	451,989.3	780.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,908,303.8	17,729,195.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	204,032,433.6	7,432,302.9

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	787,137,721.6	0.0	787,137,721.6
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	23,100,754.1	0.0	23,100,754.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	810,238,475.7	0.0	810,238,475.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	279,532.1	0.0	279,532.1
Өмчид гарсан өөрчлөлт	841,047.6	0.0	841,047.6
Зарласан ногдол ашиг	-842,254.6	0.0	-842,254.6
Тайлант үеийн үр дүн	204,032,433.6	0.0	204,032,433.6
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,014,549,234.4	0.0	1,014,549,234.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-643,605,472.4	0.0	-643,605,472.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	370,943,761.9	0.0	370,943,761.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-6,540,046.5	0.0	-6,540,046.5
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-18,129,063.6	0.0	-18,129,063.6
Тайлант үеийн үр дүн	7,432,302.9	0.0	7,432,302.9
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	353,706,954.7	0.0	353,706,954.7

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	632,865,713.6	341,712,635.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	317,438,629.3	197,808,002.3
Нийтлэг татварын бус орлого	316,982,628.8	197,362,380.1
Хөрөнгийн орлого	434,353.8	445,622.2
Тусламжийн орлого	21,646.7	0.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	315,427,084.3	143,904,632.8
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	375,696,628.0	343,534,670.8
УРСГАЛ ЗАРДАЛ	375,696,628.0	343,534,670.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	206,410,072.3	153,869,496.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	76,303,186.0	57,214,589.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,848,976.8	2,992,185.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,653,711.0	568,595.7
Хангамж, бараа материалын зардал	10,478,800.3	951,533.9
Нормативт зардал	64,626.4	53,075.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1,710,106.6	1,544,764.9
Томилолт, зочны зардал	629,724.1	73,791.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,526,106.7	12,155,057.1
Бараа үйлчилгээний бусад зардал	30,194,834.5	78,315,903.7
ТАТААС	3,774,715.0	9,598,912.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	165,511,840.6	180,066,262.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	257,169,085.7	-1,822,035.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,080,828.8	66,538.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	237,624,893.2	41,489,583.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	237,624,893.2	41,489,583.8
Дотоод эх үүсвэрээр	237,624,893.2	41,489,583.8
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-235,544,064.4	-41,423,045.6
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨНГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	9,290.0	-43,362.2
Бусад эх үүсвэр	1,005,769.4	4,280.8
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	996,479.3	47,643.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	21,634,311.3	-43,288,443.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	47,144,797.4	68,779,108.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	68,779,108.6	25,490,665.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	160,002,267,600.00	150,111,583,594.10	9,890,684,005.90	93.8
УРСГАЛ ЗАРДАЛ	117,957,919,600.00	114,993,372,036.40	2,964,547,563.60	97.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	104,881,088,000.00	101,962,169,698.40	2,918,918,301.60	97.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,128,819,100.00	50,753,090,881.77	375,728,218.23	99.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,872,044,900.00	1,763,867,162.93	108,177,737.07	94.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	312,064,700.00	241,885,593.88	70,179,106.12	77.5
Хангамж, бараа материалын зардал	121,113,300.00	120,088,360.20	1,024,939.80	99.2
Нормативт зардал	10,635,000.00	10,631,500.00	3,500.00	99.9
Эд хогшил, урсгал засварын зардал	1,722,131,400.00	1,435,391,530.00	286,739,870.00	83.4
Томилолт, зочны зардал	8,310,300.00	4,618,800.00	3,691,500.00	55.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,238,543,900.00	9,025,739,626.85	1,121,804,273.15	88.2
Бараа үйлчилгээний бусад зардал	39,467,425,400.00	38,606,856,242.77	860,569,157.23	97.8
ТАТААС	9,600,000,000.00	9,598,912,100.00	1,087,900.00	99.9
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	9,600,000,000.00	9,598,912,100.00	1,087,900.00	99.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,476,831,600.00	3,432,290,238.00	44,541,362.00	98.7
Засгийн газрын урсгал шилжүүлэг	571,268,300.00	538,749,998.00	32,518,302.00	94.3
Бусад урсгал шилжүүлэг	2,905,563,300.00	2,893,540,240.00	12,023,060.00	99.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42,044,348,000.00	35,118,211,557.7	6,926,136,442.3	83.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	160,002,267,600.00	150,111,583,594.10	9,890,684,005.90	93.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,009,149,000.00	1,116,227,207.53	-107,078,207.53	110.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	69,865,800.00	-64,865,800.00	1,397.3
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,004,149,000.00	1,046,361,407.53	-42,212,407.53	104.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	287	287	-	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	4	4	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	142	142	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	142	142	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,448,923,909.77
УРСГАЛ ЗАРДАЛ	3,293,990,609.77
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,265,370,466.01
Хангамж, бараа материалын зардал	1,823,470.00
Нормативт зардал	9,240,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	85,000,000.00
Томилолт, зочны зардал	4,381,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	114,711,130.00
Бараа үйлчилгээний бусад зардал	3,050,214,366.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,620,143.76
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,620,143.76
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	154,933,300.00
Дотоод эх үүсвэрээр	154,933,300.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,231,558,967.76
Нэмэлт санхүүжилтийн орлого	3,231,558,967.76
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-217,364,942.01
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	217,364,942.01
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд дотоод хяналтын системийг боловсронгуй болгож, дотоод аудитын хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийн түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн ХЭГ/894 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол Улсын Ерөнхий сайд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна” гэж заасны дагуу яам, Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, энэ чиглэлээр цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд тавих хяналт, шалгалт, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явцад хийх хяналт, шинжилгээ, үр дүнд өгөх үнэлгээний үр ашгийг дээшлүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчийн хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах зэрэг үйл ажиллагааг явуулж байна. Төсвийн ерөнхийлөн захирагч нь:

- Төрийн өмчийн бодлогыг хэрэгжүүлэх
- Ангилагдаагүй бусад хөтөлбөр хэрэгжүүлэх
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах
- Биеийн тамир, спортын үйл ажиллагаа зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн баталж, тус тогтоолын хэрэгжилтийг хангаж, Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас 11 байгууллагын 942,694.2 сая төгрөгийн хөрөнгийн дүн бүхий санхүүгийн тайланг ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний харьяалалд шилжүүлсэн;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт болон Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас 7 байгууллагын 151,399.5 сая төгрөгийн хөрөнгийн дүн бүхий санхүүгийн тайланг шилжүүлэн авсан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд хамааралтай дараах эрх зүйн актууд гарсан байна. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай 187;
- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 78 ;
- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 114;
- Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай 168;
- Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний 183 дугаар тогтоол тус тус болно.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтыг төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтайг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Энэ нь Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тайлант оны дотоод аудитын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг аудитын багт ирүүлээгүйтэй холбоотой байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлыг MNS 6817-4:2020 стандартын дагуу тодорхойлохдоо суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 898,713.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,987.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлант оны залруулагдсан санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 342,365.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,423.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг тооцсон нийт зардлын дүн 556,347.1 сая төгрөгөөр буурсан нь 2020 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд залруулга хийсэнтэй холбоотой болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 68,799.1 сая, эцсийн үлдэгдэл нь 25,490.6 сая төгрөг болж, 43,288.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	41.7	8.8	-32.9

Банканд байгаа бэлэн мөнгө	68,709.8	25,481.8	-43,228.0
Замд яваа мөнгөн хөрөнгө	27.6	0	-27.6
Дүн	68,779.1	25,490.6	43,288.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	28,365.2	2,427.7	-25,937.5
Засгийн газрын тусгай сан	70.6	0.0	-70.6
ТӨҮГ	40,343.3	23,062.9	-17,280.4
Дүн	68,779.1	25,490.6	43,288.5

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 43,288.5 сая төгрөгөөр буурсан нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас 67,661.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн дүн бүхий 11 байгууллагыг ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний харьяалалд шилжүүлсэн, бусад ТЕЗ-даас 2,320.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн дүн бүхий 7 байгууллага шилжиж ирсэнтэй холбоотой байна.

Кассанд байгаа бэлэн мөнгөний үлдэгдэл 8.8 сая төгрөг болж, 32.9 сая төгрөгөөр буурсан ба үлдэгдлийн 5.1 сая төгрөг төсөвт байгууллагын, 3.7 сая төгрөг төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын мөнгөн хөрөнгө байна.

Харилцах дансны үлдэгдлээрх 2,422.6 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 23,059.2 сая төгрөг арилжааны банкны харилцах дансанд тус тус байршиж байна. Арилжааны банкинд байршиж буй 19.4 сая төгрөгийн гадаад валютын үлдэгдлийн 13.5 сая төгрөг нь Харилцаа холбооны зохицуулах хорооны, 5.9 сая төгрөг Эрчим хүчний зохицуулах хорооны үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

- ТӨБЗГ-ын 2020 оны 315 дугаар тогтоолоор төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас “Хөдөө аж ахуйн бирж” ХХК 543.3 сая, УБТЗ ХНН 1,137.2 сая, “Эрдэнэс Монгол” ХХК 2,037.8 сая, “Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв” ТӨҮГ 19.2 сая төгрөгийг тус тус дутуу төвлөрүүлсэн байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 17,809.5 сая, эцсийн үлдэгдэл нь 7,946.6 сая төгрөг болж, 9,862.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	20.0	118.7	98.7
Төлбөртэй үйлчилгээний авлага	3,718.9	2,736.3	-982.6
Татаас, санхүүжилтийн авлага	512.9	0.0	-512.9
Дансны авлага /ТӨҮГ/	10,758.1	526.8	-10,231.3
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	37.5	100.3	62.8
Бусад авлага	2,762.1	4,464.5	1,702.4
Дүн	17,809.5	7,946.6	9,862.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	800.0	4,523.9	3,723.9
Төсөл хөтөлбөрийн нэгж	0.1	0.0	-0.1
Засгийн газрын тусгай сан	1,330.3	0.0	-1,330.3
ТӨҮГ	15,679.1	3,422.7	-12,256.6
Дүн	17,809.5	7,946.6	9,862.9

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын эцсийн үлдэгдэл буурсан нь ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний харьяалалд шилжсэн “Монгол шуудан” ХК-ийн 5,241.4 сая, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХК-ийн 5,087.3 сая төгрөгийн авлага хасагдсан, шилжиж ирсэн Эрчим хүчний зохицуулах хорооны 510.2 сая, Биеийн тамир, спортын улсын хорооны 3,257.9 сая төгрөгийн авлага нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэлд Харилцаа, холбооны зохицуулах хорооны 2,523.6 сая, Цөмийн энергийн комиссын ажлын албаны 35.3 сая, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 118.0 сая, Биеийн тамир, спортын улсын хорооны 3,403.7 сая, Эрчим хүчний зохицуулах хорооны 510.2 сая төгрөгийн авлагууд байна.

Харьяа байгууллагуудад хугацаа хэтэрсэн, нэгээс дээш жилийн насжилттай 4,419.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна.

Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, хууль журам хэрэгжихгүйгээс авлагын насжилт нэмэгдэх, найдваргүй авлага өсөх үр дагавартай байна.

Аудитын илрүүлэлт:

- “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ нь 1.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.
- “Буянт-Ухаа спортын ордон” ТӨААТҮГ-ын 49.3 сая, “Техник спортын төв” ТӨААТҮГ-ын 25.4 сая төгрөгийн 4-өөс дээш жилийн насжилттай авлага нь найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 12,375.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл нь 10,529.2 сая төгрөг болж, 1,846.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	9,211.5	9,782.3	570.8
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	2,040.6	420.9	-1,619.7
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	1,094.5	323.3	-771.2
Цалингийн урьдчилгаа	3.6	0.0	-3.6
Томилолтын урьдчилгаа	25.4	2.7	-22.7
Дүн	12,375.6	10,529.2	1,846.4
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	6,887.2	10,300.3	3,413.1
Төсөл хөтөлбөрийн нэгж	2,676.2	0.0	-2,676.2
ТӨҮГ	2,812.2	228.9	-2,583.3
Дүн	12,375.6	10,529.2	1,846.4

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2020 онд үүссэн 10,529.2 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээний төлбөрүүд байна. Үүнд:

- Биеийн тамир, спортын улсын хороо нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл доор 2021 оны 09 дүгээр сард явагдах “Олон улсын залуучуудын спортын ногоон наадам” арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл бэлтгэх, Спорт цогцолборын барилгын тодорхой хэсгийг санхүүжүүлэх, харилцаа болон хамтран ажиллах зохицуулалтыг хангах тухай 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 1/169 тоот гэрээний дагуу 9,490.0 сая төгрөгийг “Улаанбаатар спорт менежмент” ХК-д шилжүүлсэнтэй холбоотой үүссэн байна.
- Харилцаа холбооны зохицуулах хорооны 77.4 сая төгрөг, Эрчим хүчний зохицуулах хорооны 151.5 сая төгрөгийн тусгай зөвшөөрлийн хураамжийн үлдэгдлүүд байна.

Тус байгууллагуудын тусгай зөвшөөрөл нь 1-5 жил хугацаатай байдаг тул тайлант хугацаанд ногдох хэсгийг орлогоор хүлээн зөвшөөрдөг.

3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 21,369.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл нь 14,215.5 сая төгрөг болж, 7,153.6 сая төгрөгөөр буурсан байна.

<i>Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл</i>			<i>/сая төгрөгөөр/</i>
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	5,213.7	7,467.2	2,253.5
Дуусаагүй үйлдвэрлэл	43.1	0.0	-43.1
Бэлэн бүтээгдэхүүн	1,351.2	66.6	-1,284.6
Хангамжийн материал	14,711.8	5,616.7	-9,095.1
Биологийн хөрөнгө	0.0	1,012.8	1,012.8
Мал амьтад	49.3	52.2	2.9
Дүн	21,369.1	14,215.5	-7,153.6
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	10,962.7	13,928.5	2,965.8
ТӨҮГ	10,406.4	287.0	-10,119.4
Дүн	21,369.1	14,215.5	-7,153.6

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа, материалын дүнгийн өөрчлөлтөд урсгал төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 8,634.7 сая, шилжүүлэн авсан 4,068.3 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжиж ирсэн 942.9 сая, үнэ төлбөргүй, хандив тусламжаар авсан 0.7 сая, бусад нэмэгдсэн 277.7 сая, нийт 13,924.3 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 6,161.1 сая, шилжүүлсэн 14,530.2 сая, бусад зарлагын 386.6 сая, нийт 21,077.9 сая төгрөгөөр хасагдсан нь нөлөөлсөн байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 547,218.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл нь 77,601.9 сая төгрөг болж, 469,616.1 сая төгрөгөөр буурсан байна.

<i>Хүснэгт №5 Бусад эргэлтийн хөрөнгө</i>			<i>/сая төгрөгөөр/</i>
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад санхүүгийн хөрөнгө /ТӨҮГ/	7,041.8		-7,041.8
Бусад эргэлтийн хөрөнгө	540,176.2	77,601.9	-462,574.3
Дүн	547,218.0	77,601.9	-469,616.1
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	490,194.4	77,601.9	-462,574.3
Төсөл хөтөлбөрийн нэгж	40,347.0		
Засгийн газрын тусгай сан	9,634.8		
ТӨҮГ	7,041.8		-7,041.8
Дүн	547,218.0	77,601.9	-469,616.1

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам /хуучин нэрээр/-д хэрэгжиж байсан төсөл арга хэмжээний хүрээнд дутуу хэрэгжсэн, ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, 2010-2012 онд үүссэн 77,601.9 сая төгрөгийн 75 барилга байгууламж, 12 тоног төхөөрөмжийг бүтцийн өөрчлөлтийн хүрээнд ТӨБЗГ-ын тогтоолоор шилжүүлэн авч, бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэсэн байна.

Бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байсан 547,218.0 сая төгрөгийн үлдэгдлээс /Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сан 9,634.8 сая, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар 26,973.4 сая, Мэдээлэл харилцаа холбооны шинэчлэл төсөл 40,347.0 сая, Үндэсний хөгжлийн газар 463,220.9 сая төгрөгийг/ ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага руу шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5.6 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Хүснэгт № 6 Урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Үнэт цаас	0.5	0.0	-0.5
Нийт дүн	0.5	0.0	-0.5

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Монгол шуудан ХК-ийн 0.5 сая төгрөгийн урт хугацаат хадгаламжийн үлдэгдэл байсан нь ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний харьяалалд шилжсэн байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 472,307.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл нь 223,727.7 сая төгрөг болж, 248,579.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №7 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	330,476.6	205,505.8	-124,970.8
Биет бус хөрөнгө	136,465.1	18,221.9	-118,243.2
Бусад хөрөнгө	5,365.9	0.0	-5,365.9
Дүн	472,307.6	223,727.7	-248,579.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	155,720.0	161,985.3	6,265.3
Төсөл хөтөлбөрийн нэгж	29.8	0.0	-29.8
Засгийн газрын тусгай сан	15.8	0.0	-15.8
ТӨҮГ	316,542.0	61,742.4	-254,799.6
Дүн	472,307.6	223,727.7	-248,579.9

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгө 27,873.7 сая, шилжүүлэн авсан 3,934.5 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжиж ирсэн 107,878.1 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 1,218.5 сая, бусад нэмэгдсэн 13,322.4 сая, дахин үнэлгээний 117.9 сая, нийт 154,345.1 сая төгрөгөөр нэмэгдэж, худалдсан 80.3 сая, акталсан 2,569.9 сая, шилжүүлсэн 9,764.6 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 546,908.9 сая, бусад 6,600.4 сая, дахин үнэлгээний хорогдол 19.4 сая төгрөг нийт 565,943.5 сая төгрөгөөр хасагдсан байна.

Бусад нэмэгдсэн 13,322.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгөнд Эрчим хүчний зохицуулах хорооны дуусаагүй барилгаас барилга байгууламжид шилжүүлсэн 2,668.4 сая, үндсэн хөрөнгийн капиталжуулалтаар 36.8 сая, хандиваар нарны үүсгүүрийн байгууламж 19.4 сая, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “НАМА” төслөөс хандив тусламжаар нарны үүсгүүр 176.8 сая, цахилгаан шат, дулааны узел, хөргөлтийн болон агаар боловсруулах 241.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тус тус шилжүүлэн авч бүртгэсэн байна.

3.5.8 Өр төлбөр

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 125,310.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл нь 5,804.6 сая төгрөг болж, 119,505.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №8 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+) Буурсан (-)
Богино хугацаат зээлийн өглөг	1,406.8	0.0	-1,406.8
Өглөг	25,642.5	2,417.3	-23,225.2
Урьдчилж орсон орлого	4,277.2	2,952.7	-1,324.5
Урт хугацаат зээл	93,983.6	434.6	-93,540.0
Дүн	125,310.1	5,804.6	-119,505.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	9,981.4	1,379.7	-8,601.7
Төсөл, сан	0.7	0.0	-0.7
Засгийн газрын тусгай сан	156.1	0.0	-156.1
ТӨҮГ	115,171.8	4,424.9	-110,747.0
Дүн	125,310.1	5,804.6	-119,505.5

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 119,505.5 сая төгрөгөөр буурсан нь ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний харьяанд шилжсэн “Үндэсний Дата төв” УТҮГ-ын 220.9 сая, Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сангийн 156.1 сая, “Монгол шуудан” ХК-ийн 10,560.9 сая, “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн 7,485.5 сая, Үндэсний хөгжлийн газрын 7,917.6 сая, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХК-ийн 93,630.0 сая, Мэдээллийн Монцамэ агентлагийн 0.5 сая, “Радио, телевизийн сүлжээ” ТӨҮГ-ын 81.2 сая, “Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨҮГ-ын 304.8 сая төгрөгийн өр төлбөрүүдтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд барьцаа хөрөнгийн 1,704.9 сая, бусад өглөгийн 712.3 сая, урьдчилж орсон орлогын 2,952.7 сая төгрөг байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Эрчим хүчний зохицуулах хорооны НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “НАМА” төслөөр хандивласан 176.8 сая төгрөгийн хөрөнгө, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлсэн “Эрчим хүчний үр ашиг 3” төслийн 287.5 сая төгрөгийн хөрөнгө нийт 464.3 төгрөгийн хөрөнгийг НББОУС-20-ийн дагуу тайлант онд орлогоор хүлээн зөвшөөрсөн орлого 29.7 сая төгрөг, хойшлогдсон орлого 434.6 сая төгрөгийн өр төлбөр байна.

Аудитын илрүүлэлт:

- *Биеийн тамир, спортын улсын хороо 47.9 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.*

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Хүснэгт №9 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	139,989.3	34,911.1	-105,078.2
<i>/Засгийн газрын сан/ орон нутгийн сан</i>			
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	147,631.4	31,701.6	-115,929.8
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	137.1	0.0	-137.1
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	2,538.5	0.0	-2,538.5
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	55,197.5	1,445.1	-53,752.4
Өмнөх үеийн үр дүн	415,873.0	238,326.8	-177,546.2
Тайлант үеийн үр дүн	204,032.4	7,432.3	-196,600.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	45,764.1	39,890.0	-5,874.1
Хяналтын бус хувь оролцоо	3,523.0		-3,523.0
Дүн	1,014,549.2	353,706.9	-660,842.3
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	682,947.9	269,387.9	-413,560.0
Төсөл хөтөлбөрийн нэгж	43,052.4	0.0	-43,052.4

Засгийн газрын тусгай сан	10,895.4	0.0	-10,895.4
ТӨҮГ	277,790.6	84,319.0	-193,471.6
Дүн	1,014,549.2	353,706.9	-660,842.3

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,014,549.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл нь 353,706.9 сая төгрөг болж, 660,842.3 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд:

Төрийн өмчийн дансны үлдэгдэл 31,701.6 сая төгрөг болж, 115,929.8 сая төгрөгөөр буурсан нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоолын дагуу 11 байгууллага ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний харьяалалд шилжүүлж, бусад ТЕЗ-даас 7 байгууллага шилжиж ирсэнтэй холбоотой байна.

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн 137.1 сая, “Монгол шуудан” ХК-ийн 3,523.0 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн тул хяналтын бус хувь оролцоо, хувийн өмчийн дансны үлдэгдэл 3,660.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 39,890.0 сая төгрөг болж 5,874.1 сая төгрөгөөр буурсан, эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 1,445.1 сая төгрөг болж 53,752.4 сая төгрөгөөр буурсан, нэмж төлөгдсөн капитал дансны үлдэгдэл 2,538.5 сая төгрөгөөр буурсан, хуримтлагдсан үр дүн 245,759.1 сая төгрөг болж 374,146.3 сая төгрөгөөр буурсан нь бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн, мөн тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар 175,449.1 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 174,586.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 99.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт № 10 Төвлөрүүлэх орлого

/сая төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	174,440.0	173,470.5	-969.5	99.4
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,009.1	1,116.2	107.1	110.7
Дүн	175,449.1	174,586.7	862.4	99.5

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТӨБЗГ нь төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг 170,552.8 сая, өмч хувьчлалын 445.6 сая, түрээсийн орлого 2,472.1 сая, нийт 173,470.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Төсвийн төлөвлөлт

Тус ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг болон нийт зарлагыг 938,200.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 467,797.5 сая төгрөгөөр бууруулж 470,402.9 сая төгрөгөөр баталсан байна.

2020 оны төсвийн тухай хуулийн тодотголоор Харилцаа, холбоо мэдээллийн технологийн газар 23,966.6 сая, Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сан 3,932.0 сая, “Үндэсний дата төв” УТҮГ 11,147.1 сая, Мэдээллийн Монцамэ агентлаг 3,254.9 сая, Үндэсний хөгжлийн газар 325,582.7 сая, Төрийн худалдан авах ажиллагааны газар 1,715.9

сая төгрөгийн төсөв нь Монгол Улсын Шадар сайд, ЗГХЭГ-ын багц руу шилжиж, БТСУХ-ны 59,350.9 сая төгрөгийн төсөв нэмэгдсэнээр 160,002.3 сая төгрөгөөр батлагдсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрт зориулж батлагдсан 160,002.3 сая төгрөгийн төсвийн 117,958.0 сая төгрөгийг урсгал зардалд, 42,044.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөжээ.

Нийт зардлын 158,993.2 сая төгрөгийг улсын төсвөөс 1,009.1 сая төгрөгийг төсөвт байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 148,995.4 сая төгрөгийн санхүүжилтийг авч, үндсэн үйл ажиллагааны орлого 69.9 сая, туслах үйл ажиллагааны орлого 1,046.3 сая, нийт 150,111.6 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 5.0 сая төгрөг бүрдүүлэхээр батлагдсанаас 69.9 сая төгрөг төвлөрүүлжээ. Үүнд ТӨБЗГ, Цөмийн энергийн комиссын ажлын албаны орлого нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Туслах үйл ажиллагааны орлогоор 1,004.1 сая төгрөг бүрдүүлэхээр батлагдсанаас 1,046.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 42.2 сая төгрөгөөр, нийтдээ үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 107.0 сая төгрөгөөр тайлант онд өссөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 150,111.6 сая төгрөг буюу 93.8 хувьтай байгаа нь 2020 онд цар тахал гарсантай холбоотойгоор төсвийн хэмнэлтийн горимд шилжиж тэвчиж болох зарим зардлуудыг хэмнэж урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 2,615.3 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 40 төсөл, арга хэмжээнд 42,044.3 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 35,118.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, 31,638.4 сая төгрөгийг гүйцэтгэгч байгууллагуудад шилжүүлж, 3,479.8 сая төгрөгийг барьцаа, захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив, тусламжаар гадаадын төсөл хөтөлбөрөөс 221.8 сая, Засгийн газрын нөөц сангаас 2,342.1 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 667.7 сая, нийт 3,231.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс урсгал зардалд 3,048.1 сая, хөрөнгийн зардалд 154.9 сая, нийт 3,203.0 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 28.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газрын эхний үлдэгдэл 217.4 сая төгрөгийг ЗГХЭГ-ын даргын багц руу шилжүүлжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн баталж, тус тогтоолын хэрэгжилтийг хангаж Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагаас ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад 11, Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний 1 байгууллага шилжиж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны спортын сайд /хуучин нэрээр/-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагаас Биеийн тамир, спортын салбарын 6, Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний 1 байгууллага шилжиж ирсэн. Мөн Тагнуулын ерөнхий газрын харьяаллаас Төрийн тусгай хамгаалалтын газрыг гаргаж, төвлөрүүлэн захирагч болгосон.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас авсан хандив байхгүй байна.

Цар тахлын хөл хорионы улмаас аудитын ажлын хамрах хүрээний хувьд хязгаарлагдмал байсны улмаас аудитын хангалтай зохистой нотолгоог олж авахад хүндрэлтэй нөхцөл байдалд үүссэн.

3.8 Аудитын гол асуудал

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 4 чиглэлийн 20 ажлаас төрийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллого явуулах, санхүүгийн хяналт шалгалт явуулах, нийтийн биеийн тамираар хичээллэгчийн тоо /нийт хүн амд эзлэх хувиар/, олон улсын болон тив, дэлхийн чанартай тэмцээнээс авах медалийн тоо зэрэг үзүүлэлт нь зорилтот түвшинд хүрээгүй байна. Энэ нь тайлант хугацаанд дэлхий нийтийг хамарсан цар тахал гарч, хөл хорио удаа дараа тогтоосонтой холбоотой юм.

3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд мэдээлбэл зохих 145 мэдээллээс 144 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Харьяа байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд 97 мэдээллийг хугацаа хоцроож, 2,959.6 сая төгрөгийн 143 мэдээллийг байршуулаагүй байна.

Хүснэгт 11 Шилэн дансны хуулийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Хугацаа хоцроосон	Байршуулаагүй мэдээллийн	
		тоо	Мөнгөн дүн
Биеийн тамир, спортын улсын хороо	3	-	-
Буянт-Ухаа спорт цогцолбор ТӨҮГ	-	23	502.7
Спорт бэлтгэлийн төв ТӨҮГ Булган Хангал	78	2	21.6
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	-	1	109.1
Цөмийн энергийн комиссын ажлын алба	1	2	-
Жендэрийн үндэсний хорооны ажлын алба	2	-	-
Харилцаа, холбооны зохицуулах хороо	9	115	2,326.2
Эрчим хүчний зохицуулах хороо	4	-	-
Дүн	97	143	2,959.6

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид /бусад төсвийн ерөнхийлөн захирагч руу шилжсэнийг хассан, шилжиж ирснийг оруулсан байдлаар/ 7,398.3 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 807.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага, 412.6 сая төгрөгийн 23 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 12 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	3	7,398.3	2	63.2	1	7,335.1	53.3

Албан шаардлага	7	807.1	6	807.1	1	-	79.7
Зөвлөмж	23	412.6	22	412.6	1	-	92.2
Дүн	33	8,618.0	30	1,282.9	3	7,335.1	85.1

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “МИАТ” ТӨХК нь 2018 оны цэвэр ашгаас тооцсон 7,335.1 сая төгрөгийн ногдол ашиг дутуу төвлөрүүлсэн зөрчилд ҮАГ-аас төлбөрийн акт тогтоосон. Энэ төлбөрийн актыг “МИАТ” ТӨХК төлөөгүй бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 316 дугаар тогтоолоор чөлөөлсөн байна. Үүнийг зөрчилд тооцон ҮАГ-аас зөрчил арилгах албан шаардлага ногдуулсан байна.

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2019 оны цэвэр ашгаас төлөх 2,037.0 сая төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосныг аудитын явцад 2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр барагдуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитаар дараах асуудалд анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Биеийн тамир, спортын улсын хорооны эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын орон нутагт баригдаж буй барилга, их засварын ажил, "Олон Улсын залуучуудын ногоон наадам" арга хэмжээний санхүүжилт, хөтөлбөр арга хэмжээний зарцуулалт, хэрэгжилтийн явцыг цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үзэж чадаагүй тул хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хийгдэх гүйцэтгэлийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж байна.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа төсвийн төвлөрүүлэн захирагч 3, төсвийн шууд захирагч 4, төрийн өмчит аж ахуйн нэгж 5, Засгийн газрын тусгай сан 1, төсөл, хөтөлбөрийн нэгжийн 1, нийт 14 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, 8 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 2 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

4.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 21,162.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 13,185.4 сая төгрөгийн алдааг залруулж, 3,758.3 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтээр 2,960.3 сая төгрөгийн дүн бүхий 7, бусад 317.4 сая төгрөгийн 12 зөрчлийг арилгах албан шаардлага тус тус хүргүүлж, 941.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 36 зөвлөмж өгсөн байна.

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 556,347.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 556,347.2 сая төгрөгийн алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагаас ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад шилжиж буй 556,347.2 сая төгрөгийн зардлын гүйлгээг нэгтгэсэн үр дүнгийн тайланд илүү тайлагнасныг залруулсан.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

1.Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгийн дансанд өмнөх онуудаас шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа 77,601.9 сая төгрөгийн дуусаагүй барилга, байгууламж бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" гэж заасныг мөрдлөг болгоогүй.

1.2 Өгсөн зөвлөмж:

Шилжиж ирсэн дуусаагүй барилгын хадгалалт хамгаалалт, ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлэх;

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.10-т "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "энэ хуулийн 3.1.1-д Төсвийн байгууллага албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Харьяа байгууллагуудад тавих дотоод хяналтыг сайжруулж, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/											
дд	Харьяа байгууллагууд	Дүгнэлтийн хэлбэр				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таагалдсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн ерөнхийлөн захирагч											
1	Ерөнхий сайд	1				-	-	-	-	2	
	Дүн	1						-		2	
Төсвийн төвлөрүүлэн захирагч											
1	Тагнуулын ерөнхий газар	1				1	3,500.0	2	2,700.0	4	388,700.0
2	Төрийн тусгай хамгаалалтын газар	1				1	15,000.0	1	12,800.0	3	33,500.0
3	Биеийн тамир, спортын улсын хороо		1			-	-	3	47,900.0	5	193,900.0
	Дүн	2	1			2	18,500.0	6	63,400.0	12	616,100.0
Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж											
1	Харилцаа, холбооны зохицуулах хороо	1						1	2,326.2	5	31.3
2	Эрчим хүчний зохицуулах хороо	1						1	-	2	13.4
3	Техник спортын төв ТӨҮГ							1	25.4	1	63.4
4	Булган Хангал спорт бэлтгэлийн төв					1	2,331.2	2	21.6	5	19.2
5	Буянт-Ухаа Спорт цогцолбор		1			-	-	3	552.1	6	100.3
	Дүн	2	1			1	2,331.2	8	2,925.3	19	227.6
Төсвийн шууд захирагч											
1	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	1				4	3,737.5	3	288.9	3	89.7
2	Цөмийн энергийн комиссын Ажлын алба	1					-	1	-	1	2.1
3	Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба	1					-	1	-	1	5.9
	Дүн	3				4	3,737.5	5	288.9	5	97.8
15	НИЙТ ДҮН	8	2			7	3,758.3	19	3,277.7	38	941.5

6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая. төг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
Биеийн тамир, спортын улсын хороо					
1	Биеийн тамир, спортын улсын хороо нь 47.9 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.0	47.9	Албан шаардлага	Дарга, СХОХ-ийн дарга	Д.Шаравжамц, Э.Адъяасүрэн
2	2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанаас 11 хоног хоцроосон	-	Албан шаардлага	Дарга, СХОХ-ийн дарга	Д.Шаравжамц, Э.Адъяасүрэн
3	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээлэл байршуулахаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	-	Албан шаардлага өгөх	Дарга, СХОХ-ийн дарга	Д.Шаравжамц, Э.Адъяасүрэн
Булган хангал Спорт бэлтгэлийн төв ТӨҮГ					
4	Спорт бэлтгэлийн төв нь 2.3 сая төгрөгийн орлогыг дутуу бүртгэж, тайланд тусгаагүй байна.	2.3	Төлбөрийн акт	Захирал, Нягтлан бодогч	О.Баярбат, О.Батдэлгэр
5	2020 онд эргэлтийн хөрөнгийн тооллого хийгээгүй байна.	-	Албан шаардлага	Захирал, Нягтлан бодогч	О.Баярбат, О.Батдэлгэр
6	Шилэн дансны цахим хуудсанд нийт 168 мэдээлэл байршуулснаас 78 мэдээлэлийг хугацаа хоцроож, 21.6 сая төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй байна.	21.6	Албан шаардлага өгөх	Захирал, Нягтлан бодогч	О.Баярбат, О.Батдэлгэр
Буянт-Ухаа спорт цогцолбор ТӨААТҮГ					
7	Буянт-Ухаа спортын ордны барилгыг улсын комисс хүлээн аваагүй,эрх зүйн баримт бичиг байхгүй байна.	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Л.Энхбаяр, Л.Одонгуа
8	Авлагын үлдэгдэлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаа-гүй 4 харилцагчийн нийт 49.4 сая төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн он дамжсан авлага байна.	49.4	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Л.Энхбаяр, Л.Одонгуа
9	Шилэн дансны цахим хуудсанд тайлант онд орлогын 332.4 сая төгрөгийн 16 мэдээлэл, зарлагын 170.3 сая төгрөгийн 7 мэдээлэл байршуулаагүй.	502.7	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Л.Энхбаяр, Л.Одонгуа
Техник спортын төв ТӨААТҮГ					

10	Техник спортын төв ТӨААТҮГ нь он дамжсан 25.4 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.	25.4	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Наран-Идэр Д.Алтанчимэг
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар					
11	Хөдөө өж ахуйн бирж ХХК 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг улсын төсөвт төвлөрүүлээгүй	543.3	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Б.Цэнгэл, Ж.Мөнхтүвшин
12	УБ Төмөр зам ХХН 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг улсын төсөвт төвлөрүүлээгүй	1,137.2	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Б.Цэнгэл, Ж.Мөнхтүвшин
13	Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв' ТӨҮГ 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг улсын төсөвт төвлөрүүлээгүй	19.2	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Б.Цэнгэл, Ж.Мөнхтүвшин
14	Эрдэнэс Монгол ХХК 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг улсын төсөвт төвлөрүүлээгүй	2,037.8	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Б.Цэнгэл, Ж.Мөнхтүвшин
15	Өмнөх аудитаар МИАТ ТӨХК нь тогтоосон актыг чөлөөлсөн байна.	-	Албан шаардлага өгөх	Дарга, Нягтлан бодогч	Б.Цэнгэл, Ж.Мөнхтүвшин
16	Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй.	109.7	Албан шаардлага өгөх	Дарга, Нягтлан бодогч	Б.Цэнгэл, Ж.Мөнхтүвшин
17	"Төрийн өөрийн эд хөрөнгийн түрээслүүлэх журам"-ын дагуу түрээсийн орлогын авлага, өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй	179.1	Албан шаардлага өгөх	Дарга, Нягтлан бодогч	Б.Цэнгэл, Ж.Мөнхтүвшин
Харилцаа, холбооны зохицуулах хороо					
18	Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.	2,326.2	Албан шаардлага өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Г.Чинзориг Н.Халиунаа
Эрчим хүчний зохицуулах хороо					
19	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 692 мэдээллээс 688 мэдээллийг хугацаанд нь оруулж, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Албан шаардлага өгөх	Хорооны дарга, нягтлан бодогч	А.Тлейхан, М.Мандах.
Цөмийн энергийн комисс ажлын алба					
20	Шилэн дансанд байршуулах зарим гүйлгээг дутуу байршуулсан бөгөөд хандив тусламжтай холбоотой мэдээллийг байршуулаагүй санхүүгийн тайланг 3 хоног хоцроосон, аудитын дүгнэлт тайланг байршуулаагүй	-	Албан шаардлага өгөх	Дарга, Нягтлан бодогч	Г.Манлайжав Н.Нямдулам
Жендэрийн үндэсний хорооны ажлын алба					
21	Шилэн дансанд 2 мэдээ хугацаа хоцролттой байсан	-	Албан шаардлага өгөх	Дарга, Нягтлан бодогч	Т.Энхбаяр, Б.Гантуяа
Нийт дүн		7,036.0			